

2008/09,10 №05(08)



ШИНЖЛЭХ УХААН ТЕХНОЛОГИЙН
ИХ СУРУУЛЬ
ТӨВЛӨРСӨН НОМЫН САН

Энэ дугаарт



2008 оны эхний хагас жилийн фонд бүрдүүлэлт	...2
2008 оны 9, 10 сарын шинэ номын мэдээ	...3-37
ОХУ-ын “АСВ” хэвлэлийн газраас ном хүлээн авлаа	...38
Ректорын тушаал гарлаа	...39
БСШУ-ы сайд Ё.Отгонбаяр манай сургуульд зочиллоо	...40
Ховд Их Сургуулийн удирдлага төв номын сантай танилцлаа	...40
Төв номын санд ном бэлэглэж, хандивлав	...40-42
Нээлттэй хаалганы өдөр	...42-44
Төв номын сангийн үйлчилгээ	...45 - 46
Үзэсгэлэнгийн хуваарь	...45

Улаанбаатар хот
2008 он

Төвлөрсөн номын сан

ШУТИС-ийн Төв номын сангийн 2008 оны
фонд бүрдүүлэлтийн тооцоо

2008-10-30-ны байдлаар

№	Сургуулийн нэрс	Ном сурах бичгийн нийт	60%-н зардал /мян.төг/	Үүнээс: Авсан ном сурах бичиг			Багш нарын ном сурах бичиг авах үлдэгдэл зардал /төг/
				Төрөл	Тоо ширхэг	Үнэ /төг/	
1	БИАС	20000.0	12000.0	21	411	3345700	8654300
2	УУИС	8000.0	4800.0	38	784	5774500	+
3	ЭХИС	15000.0	9000.0	11	370	2487000	6513000
4	ГТТС	7400.0	4440.0	21	285	2002500	2437500
5	ХБТС	10500.0	6300.0	13	205	1530000	4770000
6	МГС	3500.0	2100.0	4	90	317000	1783000
7	МС	4500.0	2700.0	8	155	890025	1809975
8	ХБС	5350.0	3210.0	3	106	475220	2734780
9	ХУС	3000.0	1800.0	8	158	939500	860500
10	КТМС 10%		1680.0	3	60	350000	1330000
11	ҮТДС 10%		1200.0				1200000
12	ХМГС 10%		1500.0	2	40	350000	1150000
13	МИС 10%		1100.0	4	43	395000	705000
	Нийт:	77250.0	51830.0	136	2707	18856445	33948055

ШУТИС-ийн Төвлөрсөн дансанд шилжүүлсэн 40 %-н төвлөрлийн байдал

2008-10-15-ны байдлаар /Мян.төг/

№	Сургуулийн нэрс	Нийт төвлөрүүлэх зардал /40%/	Үүнээс		6-12 сард шилжүүлсэн байдал	Дутуу
			1-6 сард шилжүүлсэн	6-12 сард шилжүүлэх		
1	БИАС	8000.0	4951897	3,048,103	1548103	1500.0
2	УУИС	3200.0	1600.0	1600.0	1600.0	
3	ЭХИС	6000.0	5101697	898303	898303	
4	ГТТС	2960.0	1480.0	1480.0	1480.0	
5	ХБТС	4200.0	4831807			
6	МГС	1400.0	700.0	700.0	600.0	100.0
7	МС	1800.0	900.0	900.0		
8	ХБС	2140.0		2140.0	1070.0	1070.0
9	ХУС	1200.0		1200.0	1200.0	
	Нийт:	30900.0	19565401	12466406	9296406	2670.0

2008 оны 9, 10 сард Төв номын сан нийт 40 төрлийн 175 ширхэг шинэ ном, сурах бичиг авсан

Техник, технологийн чиглэлээр:



Монголия: Сборник научных трудов. Отдельный М77 выпуск Горного информационно-аналитического бюллетень / Ред. коллегия ГИАБ главный редактор П.А.Пучков, Зам. гл. ред. Л.Х.Гитис, Члены редколлегии Д.Р.Каплунов и др., Редакционная коллегия международного выпуска “Монголия” Председатель П.Очирбат, Члены редколлегии Л.Пүрэв, Ч.Гульнар, Б.Мандах и др. - 2008.- №ОВ1.- 436с.- М.: МИР ГОРНОЙ КНИГИ., ISSN 0236-1493

Монголын уул уурхай, геологи, барилга, механикийн мэргэжлийн эрдэмтдийн нэгдсэн бүтээлүүд эмхтгэгдэн орсон байна. ШУТИС 500 ширхэгийг хамтын гэрээний дагуу авсан болно. Энэхүү ном нь уншигчдын эрэлт хэрэгцээтэй номын тоонд орж “Эрдэнэт” үйлдвэр уг номоос 100 ширхэгийг захиалаад байна.

УУИС. МИС



Техникийн механикийн жишээ бодлого / Ч.Авдай, Г.Арваазана, Ш.Балжинням, ба бус ; Ред. А.Гөлгөө.- УБ., 2008.- 532х.- ISBN 978-99929-1-362-2

Энэхүү гарын авлагад техникийн их дээд сургуулиудад заагддаг онолын механик, машин механизмын онол, материалын эсэргүүцэл, машины эд ангийн хичээлүүдийн үндсэн бүлгүүдийг судалж, чадвар дадалтай болоход нэн шаардлагатай олон тооны жишээ оруулж бие дааж бодох бодлогууд оруулсан байна. Техникийн их дээд сургууль коллежид суралцаж буй бакалавр, магистр, доктор оюутнууд, механикийн багш нар, инженер, технологичдод зориулагдсан.



Хэрэглээний механик 1 / Д.Батбаяр, Ц.Оюунгэрэл, П.Баасансүрэн, ба бус; Ред. П.Пүрэвжав.- УБ., 2003.- 144х.

Гарын авлага нь лекц, семинарын хичээлээр олж авсан онолын мэдлэгийг бататгах, бие даалтын ажлаар бодлого бодуулах, төрөл бүрийн тооцоо хийлгэж сургахын зэрэгцээ техникийн сэтгэлгээ, авьяасыг хөгжүүлэх, онол практикийн холбоогүй ойлгуулахад чухал хувь нэмэр болно.

Бие даалтын ажлын даалгаврын өгөгдлийг тооцооны бүдүүвч, хүснэгтээр өгсөн бөгөөд тэдгээрийг хэрхэн бодох, шаардлагатай онолын үндэслэлийг товч тайлбарласан жишээнүүдийг үзүүлсэн болно. Хэрэглээний механик 1 хичээлийг судлаж буй бүх оюутнуудад зориулсан.

Түмэнжаргал А.

**Adobe Flash professional:
Хэрэглэгчийн хөтөч. –УБ.: ForWindows
Macintosh., 2007.- 160х.**


Flash программыг бүрэн судлахын сацуу график объект, филтер болон эффект, animation буюу хөдөлгөөнт дизайны суурь ойлголтыг эзэмшин олж авсан мэдлэгээ практик дээр шууд ашиглах чадвартай болох юм.



Түмэнжаргал А.

**Adobe Photoshop CS v8.0:
Хэрэглэгчийн хөтөч.- УБ.: ForWindows
Macintosh., 2006.- 189х.**

Энэхүү номонд Adobe Photoshop программын талаар зургаар дэлгэрэнгүй тайлбарлаж өгсөн нь хэрэглэхэд хялбар байна. Шинээр давхарга болон бүлэг давхарга үүсгэх, филтер буюу хялбар эффектийг ашиглах, бичгийн хэрэглүүрийн тухай дэлгэрэнгүй тусгасан.





Уайт, Эндрю

Статистические методы работы с электронными документами в библиотечной сфере, или Э-метрики / Эндрю Уайт, Эрик Джива Камаль.- Москва.: Омега-Л., 2006.- 393с. ISBN 5-365-00248-2

Энэ номноос фонд ба номын сангийн реферат, бүрэн эхээрээ орсон сэтгүүл, электрон номнууд, өгөгдсөн эрдэм шинжилгээний бааз зэрэг тооны ба электрон эх үүсвэрийг ашиглах эдийн засгийн үр ашиг дүн шинжилгээ хийхэд


зориулагдсан хэрэгслүүдийн чанарын э-метрикуудийг уншиж болно. Бэлтгэгдсэн техникийн ажилтнуудад зориулагдсан зарим практик бодлогуудыг оруулсан байна.

Мак Менеми, Дэвид

Предоставление электронных услуг: Рук. Для публичных б-к и центров обучения / Дэвид МакМенеми, Алан Поултер.- Москва.: Омега-Л., 2006.- 248с. ISBN 5-365-00247-4



Энэ ном нь өөртөө электрон үйлчилгээний ашигтай сүлжээг байгуулах ба хөгжүүлэхэд сургах төв ба зориулсан номын сангийн мэргэжилтнүүдэд зориулагдсан удирдлагын дадлагуудыг агуулсан байна. Ном нь мэдээллийн ба харилцааны мэдээллүүдийг хэрэглэх тухай болон сүлжээг удирдах, вэб-дизайн болон тооны электрон сургалтуудыг багтаасан мэдээллүүдийг агуулсан байна. Номын сан-мэдээлэлзүйн албадууд мэдээллийн ба харилцааны мэдээллүүдийг хэрэглэх дадлага ажилд анхаарсан байна.



Насанжаргал Д.

Компьютер сурах гарын авлага .- УБ.: Адмон., 2008.- 100х.- ISBN 99929-0596-6

Энэхүү ном нь компьютер эхлэн суралцагсдад зориулагдсан бөгөөд компьютерийн тухай ерөнхий ойлголт, техник хангамж, программ хангамж, болон өдөр тутмын хэрэглээний программуудын тухай ойлгомжтойгоор харуулсан байна. Мөн компьютерийн сүлжээ, интернет, нэр томъёоны тайлбарыг товчхон оруулсан байна.



Меллинг, Мэксин
Электронное обучение: Рекомендации руководителям библиотечных и информационных служб / Под ред. Мэксин Меллинг; пер. с англи. Н.А.Багровой, К.Э.Корбут.- Москва.: Омега-Л., 2006.- 224с.- ISBN 5-365-00249-0

Номын сан ба мэдээллийн үйлчилгээг удирдаж байгаа зориулсан электрон боловсролыг хангасан зарим стратегийн асуудлуудыг энэ түүвэр номонд оруулсан байна. Элетроны орчинд суралцагчдад юу хэрэгтэй байна вэ? E-learning орчинд номын сан-мэдээлэл зүйн алба ямар үүрэг гүйцэтгэж байна, нэмэлт ямар үйлчилгээг үзүүлэх хэрэгтэй байна гэдгийг энэхүү номноос уншиж болно.

Хөнгөн аж үйлдвэр:
Сэтгүүл / Ред.Ч.Авдай.- УБ.: ШУТИС-ийн ХҮСТ., 2008/01.- 46х. ISBN 99929-3-051-9

Энэхүү сэтгүүл нь шинжлэх ухаан, технологи, мэдээллийн улирал тутам хэвлэгдэн гардаг сэтгүүл юм.

Энэ дугаарт:

- Сүлжмэл эдлэлийн зохион бүтээлтийн хэрэглээний программ
- Хөдөлмөрийн зах зээл дээр тулгарч буй бэрхшээлүүд
- 95 жилийнхээ ойтойгоо золгож буй монголын хэвлэх үйлдвэрийн салбарын хөгжлийн тойм
- Хэвлэлийн хэвийг янз бүрийн аргаар бэлтгэх технологийн процесс
- Ноос ноолууран бүтээгдэхүүний чанарын хяналт, тулгамдсан асуудал ... зэрэг мэдээллүүд багтсан байна.



Боловсрол, соёл, шинжлэх ухаан:

Доржжав Д.

**Удирдахуйд суралцах нь /
Ред.Я.Шуурав.- УБ., 2008.- 450х.
ISBN 99929-0-381-3**



Уг номонд удирдлагын бодит жишээнүүд дээр яавал үр бүтээлтэй ажиллах боломжтой, шийдвэр гаргах арга барилд хэрхэн яаж бие даан суралцах асуудлыг сэтгэл судлал, удирдахуйн ухаан, хүний нөөцийн мэдэгдэхүүнүүдийг өөр хооронд нь уялдуулж ашиглах замаар оюуны үндсэн 8 үйлдлийг дэс дараатай чамбай гүйцэтгэх хэрэгтэй, асуудлыг шийдэх боломжтой хэмээн үзэж энэ бүх арга ажиллагааг бодитоор харуулсан нь

сайшаалтай, шинэлэг ажил болсон байна. Энэ номонд онолын хураангуйлсан хэсгээс гадна янз бүрийн эх сурвалжаас түүвэрлэн орчуулсан төрөл бүрийн сонгодог жишээг эмхтгэн оруулсан ба сургалт арга зүйн шийдэл, зориулалтын хувьд сонирхолтой санаа дэвшүүлж байгаад уг бүтээлийн практик ач холбогдол оршино.

Доржжав Д.

**Сэтгэл зүйд өөрөө суралцах нь
/ Ред.Я.Шуурав.- УБ., 2005.- 778х.
ISBN 99929-0-363-5**



Энэхүү сурах бичигт сэтгэл судлалын мэдлэгийн үүсэл хөгжил, ирээдүйн төлөв, хандлага болон судалгааны арга зүй, зохион байгуулалт, сэтгэл судлал бусад шинжлэх ухаануудын уялдаа холбоо, хүн ба амьтдын сэтгэцийн онцлог, биологи ба физиологи сэтгэл судлал, уураг тархи ба сэтгэц, сэтгэц зан үйлийн анатом-физиологи, генетикийн үндэс зэрэг өргөн хүрээг хамарсан байна. Хүний ажиллагаа ба танин мэдэхүйн сэтгэл зүй, үйл явц, ой тогтоолт ба танин мэдэхүй, бие хүний хөгжлийн талаарх дорны онолуудын талаар дэлгэрэнгүй бичсэн байна.

Циен-Ойдов Д.

Боловсрол сургалт ой тогтоолт / Хянан тохиолд. Д.Доржжав.- УБ.:Урагш-Оргил., 2008.- 312х.- ISBN 978-99929-1-403-3



Уг ном нь боловсролын уламжлалт болон орчин үеийн онолын үзэл баримтлалыг сургалтанд хослуулан хэрэглэх, сургалтын физиологи, сэтгэл зүй танин мэдэхүйн үндэс, ой тогтоолтыг даган сургалтанд ашиглах зэрэг бие хүний хөгжилд нөлөөлөх хүчин зүйл, мөн чанарын тухай тусгасан байна. Оюутан, сонсогч, магистрант, докторант, судлаачдад зориулагдсан.



Доржжав Д.

Сэтгэл зүйн тусламж заслын арга зүйн үндэс / Ред. Д.Лхаашид.- УБ., 2005.- 278х. ISBN 99929-0-483-6


Энэхүү номонд хүний дотоод мөн чанар, дахин давтагдашгүй хувийн өвөрмөц онцлог, зан үйлийн өв тэгш хөгжил, бүтээн туурвих ба өөрийгөө хэрэгжүүлэх ашиглагдаагүй боломж, увидсын сэтгэл зүйн механизмыг нээн илрүүлэх шаардлагатай байгааг дурьдан арга замыг тусган харуулж, оюун ухааны чадавхи, сэтгэлгээний хурд, ертөнцийн юмс, үзэгдлийг

танин мэдэх боломжийнхоо 8-10% -г хүмүүс ашигладгийг дурьдан оюун ухаан, сэтгэл санааг эзэмдэн жолоодож чаддаг байх хэрэгтэй гэсэн байна. Энэ ном тэр талаарх мэдээллийг нилээд цогц байдлаар уншигчдад хүргэж байгаа нь их үр дүнтэй болно

Доржжав Д.

Харилцааны сэтгэл зүйн ертөнц / Ред. Я.Шуурав.- УБ., 2008.- 746х. ISBN 978-99929-0-439-9

Ном нь 9 бүлгээс бүрддэг ба 1-р бүлэгт харилцааны сэтгэл зүйн үндсэн мэдлэг, мөн чанар ба сэтгэл зүйн тухай үндсэн ойлголтоос эхлэн харилцааны үйл явц, сэтгэц, практик чиглэлүүд болон шийдлүүдийн тухай авч үзсэн бол, өөрийн харилцааны сэтгэл зүйн үндэс төлөвших үйл явц, нөхцөлдүүлэгч хүчин зүйлс, харилцааны боломж нөөцийг танин мэдэх, нээх арга замуудын тухай 2-р бүлэгт авч үзсэн байна. Мөн бие хүн хоорондын харилцааны сэтгэл зүй, зан үйл, хамт олон, байгууллагын харилцааны сэтгэл зүйн үйл явц, харилцааны сэтгэл зүй болон ёс зүйн шүтэлцээний тухай дараагийн бүлгүүдэд дэлгэрэнгүй тусгасан.



Өлзийсайхан Д.

Монголын үндэсний сэхээтэн: Үүсэл, хөгжлийн зүй тогтол, хувь тавилан / Ред.С.Төмөр-Очир.- УБ.: Бит Пресс., 2007.- 518х.- ISBN 99929-73-78-1

Энэхүү номонд монголын үндэсний сэхээтний үүсэл хөгжил, түүний нийгэмд эзлэх байр суурь, үүрэг роль, тэдний төлөвшилд нөлөөлсөн нийгмийн хүчин зүйлс, учир шалтгаан буюу диалектикийг авч үзсэн байна.



Өлзийсайхан Д.

Удирдлагын сэхээтэн
/ Ред.Д.Павлик.- УБ.: Бит Пресс., 2008.-
200х.- ISBN 999295987-8

Уг номонд удирдлагын сэхээтэн гэж ямар байх ёстойг дурьдан, ер нь сэхээтэн гэдэг нь хаанаас гаралтай, хэдийд бий болсон, монголын үндэсний сэхээтний төлөвшил, хөгжилд нөлөөлсөн түүхэн нөхцөл, хүчин зүйл, үндэсний сэхээтнийг бэлтгэсэн арга замын талаар товч өгүүлсэн.

Өлзийсайхан Д.

Дипломат сэхээтэн- I / Ред.
Д.Павлик.- УБ.: Бит Пресс, 2007.- 209х.
ISBN 999297378-1

Уг номонд монголын ахмад дипломатуудын тухай товч танилцуулга орсон ба дипломат хэргийг эрхлэн явуулдаг субъект, объектийн тухай товч өгүүлэн, дипломат байгууллага, дипломатч гэж хэн юм хэмээсэн ойлголтуудыг тайларлан оруулсан. Нийт 205 гаруй дипломатчдын танилцуулга орсон байна.




Өлзийсайхан Д.

**Багш сэхээтэн / Ред. Д.Павлик.- УБ.:
Бит Пресс, 2008.- 152х.- ISBN 999295987-8**



Энэхүү номонд сэхээтний тухай товчхон дурьдаж, тэдний төлөвшил, хөгжилд нөлөөлсөн улс төр, эдийн засаг, оюун санааны хүчин зүйлс, үндэсний сэхээтний өнөөгийн байдал ба тоо, чанар, мэргэжлийн бүтэц, үүрэг роль зэргийг тусган харуулсан. Багш сэхээтэнд холбогдсон зарим статистик баримт болон монголын ахмад үеийн багш сэхээтний фото зургийг оруулсан байна.



Бат-Очир Р.


Урлахуйн гайхамшиг / Хянан тохиолд. С.Бадрал.- УБ.: Адмон., 2008.- 59х.

Энэхүү ном нь монголын уран зургийн өнөөгийн байдал, хөгжлийг харуулж өгсөн. Мөн монгол дүрслэх урлагийн төлөөлөгчид болох Д.Бадам, Л.Бумандорж, Ц.Бүдбазар, Ц.Нарангэрэл, Я.Оюунчимэг... зэрэг зураачдын товч намтар уран бүтээлээс дурьдсан байна.

Каиро

Хувь заяа ба аз жаргалын тухай ном: Одны зурхай/ Орч. Н.Нансалмаа .- УБ., 2008.- 223х.

Энэхүү номноос одны зурхайн тухай дэлгэрэнгүй уншиж мэдэх бөгөөд өөрийгөө болон ойр дотныхоо хүмүүсийг таньж мэдэн аз жаргал, амжилтанд хүрэх түлхүүрийг олж авч чадах бөгөөд ирээдүйгээ урьдчилан мэдэх чадварт суралцах болно.



Туяа Т.

Дэлхийн нэрт сэтгэл судлаач эрдэмтдийн шилмэл зохиолын хураангуй / Д.Доржжав.- УБ., 2008.- 248х. ISBN 978-99929-0-440-2

Энэхүү номонд дэлхийн алдартай сэтгэл судлаачдын бүтээлийг түүвэрлэн оруулсан. Оюун санаа, эрх чөлөө, хариуцлага, сэдэл ба бие хүн, сэтгэцийн эрүүл мэнд ба нийтлэг тогтсон хандлага, хүмүүжил ба зан үйл, хүүхэд нас ба нийгэм, бусдыг мэдэрч сурах нь, соёл ба мэдрэлийн өвчин, хайр сэтгэлийн онол, сэтгэл зовоосон асуудлыг шийдэхэд тусалдаг шидэт томъёоны тухай зэрэг сонирхолтой бүтээлүүд байна.

Танин мэдэхүй, нэвтэрхий толь, лавлах:





Нэвтэрхий толь: Britannica 2006.- DVD.

Энэхүү DVD-д 100 мянга гаруй зурагтай өгүүллэг, 800 мянга гаруй англи хэлний үг, 2514 газрын зураг орсон байна. Мөн дэлхийн эдийн засаг, соёл, нийгмийн мэдээллийг энэ DVD - с цахим хэлбэрээр унших боломжтой.

Өлзийбямба Н.

Уламжлалт болон үйлдвэрлэлийн аргаар дээсэн бүтээгдэхүүн хийх арга ажиллагаа, тоног төхөөрөмж / Ред. Ч.Авдай.- УБ.: Согоо нуур., 2007.- 95х. ISBN 978-99929-65-23-1


Энэхүү номонд дээс, дээсэн эдлэл хийх түүхий эдийн бүтэц, физик механикийн шинж чанар, үс хялгасны бөх бат, тасралт, суналт, чийг шингээх чадвар, тослог, эрч авах чадвар буюу мушгиралт зэрэг үзүүлэлтүүдийг лабораторийн нөхцөлд тохируулах аргачлал болон тоон үр дүнг оруулсан байна.



Ням-Осор Т.

Түнэр харанхуйг зүхэж суухаар нэг ч гэсэн лаа асаа / Хянан тохиолд. Т.Амартүвшин.- УБ.: Бит Пресс., 2008.- 160х.

Ном нь 2 хэсгээс бүрдэж байна. Эхний хэсэгт дэлхийн 30 алдартныг цаг хугацааны дарааллаар товч намтрыг нь оруулсан ба тэдгээр хүмүүсийн хэлсэн мэргэн үгс орсон байна. Дараагийн хэсэгт 180 гаруй хүмүүсийн хамгийн оновчтой, шилмэл гэсэн үгсийг түүвэрлэн авч оруулсан байна.



Мөнхбаяр В.

Гандан хийдийн тайлбар
/ Ред.С.Амаржаргал.- УБ., 2008.- 104х.

Энэхүү номонд сүүлийн жилүүдэд эрчимтэй хөгжиж буй аялал жуулчлалын талаар, мөн зохион байгуулагч хөтөч тайлбарлагчийн мэргэжлийн онцлог ямар байх тухай харуулсан. Монголын томоохон хийдүүдийн бүтэц, зохион байгуулалтын талаар тусгасан.

Өлзийсайхан Д.

Анекдоты буюу ардын аман зохиол / Хянан тохиолд. Д.Павлик.- УБ.: Содпресс, 2008.- 592х. ISBN 978-99929-54-50-7



Зохиогч хэлэхдээ: хүний амьдралыг байнга дагаж ирсэн нэг чухал зүйл бол хөгжилтэй, наргиантай, хошин яриа агаад энэ нь хүний сэтгэлийг сэргээж, хөгжөөж инээд баяслыг ямагт тээн авчирч ажил, амьдралд нь урам хайрлаж, сэтгэл санааг хөглөж, засах эм болж ирсэн ажээ. Хүнийг эргэн тойрсон хөгжилтэй, баргар хоёр янзын орчин байгаа хэмээнэ. Энэ нь орчинг бүрдүүлж буй хэн хүний хувийн зан төлөв араншинтай шууд холбоотой байдаг гэжээ.



Цэрэндулам З.

Мартагдашгүй гэгээн дурсамж
/ Ред.Б.Лхагвасүрэн.- УБ.: Мөнхийн үсэг, 2008.- 334х.

Монголын эх оронч үзэлтэй сэхээтнүүдийн амьдрал тэдний хойч үеэ эрдэм боловсролтой болгохыг зорьж байсан хичээл зүтгэлийн тухай мөн монголд тайз чимэглэлийн болон уран баримал хөгжиж эхэлсэн түүхийн он цагуудыг дэлгэрэнгүй бичсэн байна.



Лхагвасүрэн Б.

Уянгын тойрог: Тэргүүн давтэр.-
УБ.-228х.

Гашуун өвс: Дэд дэвтэр.- УБ.-
176х.

Цэцгийн манан: Гутгаар дэвтэр.-
УБ.- 264х.

Майкл Х. Харт

Дэлхийн түүхийн суут 100 хүн
/ Орч. Д.Өлзийсайхан.- УБ.: Соёмбо,
2007.- 266х.

Эл номонд хүн төрөлхтөний түүхэнд үзүүлсэн нөлөө нь үнэхээр их 100 хүний намтар үйл ажиллагааг өгүүлсэн байна. Зохиолч өгүүлэхдээ: Үүнд хамгийн гол нь тухайн хүний үйл ажиллагааны аугаа гайхамшигийг биш чухамдаа хүн төрөлхтөний түүхийн явцад тэдний үзүүлсэн нөлөөний хүчирхэг хүчин чадлыг гол үндэслэл болгосон юм гэжээ.



Эдийн засаг, маркетинг, менежмент:

Чадраабал Д., Будханд С.

Зах зээл, төлөвлөлт I.- УБ.,
2006.- 120х.- ISBN 99929-6-524-X



Энэхүү номонд зах зээл төлөвлөлтийн талаархи шинжлэх ухааны баримтлал, эдийн засгийн тогтолцоо, микро түвшний аж ахуйн нэгжийн төлөвлөгөө, стратеги төлөвлөгөө боловсруулах үлгэрчилсэн заавар зэрэг зах зээлийн эдийн засгийн чухал баримтлалуудыг ойлгомжтойгоор харуулсан. Их дээд сургуулиудын оюутан, сонсогчид пүүс, компани, аж ахуйн нэгж

байгууллагын удирдагч нарт зориулагдсан.



Чадраабал Д., Будханд С.

**Зах зээл, төлөвлөлт II .- УБ.,
2008.- 87х.**

Энэхүү номонд дэлхийн зах зээлийн харилцаа өндөр хөгжсөн орнуудын аж ахуйгаа эрхлэн хөтлөж буй арга, орчин үеийн менежментийн үндсэн функц болох төлөвлөлтийн агуулга, мөн чанар, шинжлэх ухааны үзэл баримтлалыг оновчтой илэрхийлж, өрх гэр, хувь хүний түвшний төлөвлөлтийн асуудлыг зөв хөндөж, стратегийн болон бизнес төлөвлөгөө боловсруулах арга зүй аргачлалыг дэвшүүлэн тавьсан. Мөн хувь хүн, өрх гэрийн түвшинд төлөвлөгөөтэй ажиллахын ач холбогдлыг зөв тодорхойлж, энэ тухай дурьдсан гадаадын болон өөрийн орны эрдэмтэн мэргэдийн сургаалаас оруулсан нь оновчтой болсон байна.

Батбаяр Б.

**Жижиг дунд бизнесийн
менежмент сурах бичиг**
/ Ред.Н.Дашзэвэг.- УБ.: Сэлэнгэпресс,
2008.- 261х.- ISBN 976-99929-0-261-2



Жижиг дунд бизнесийн үүсэл хөгжил, өнөөгийн байдал, түүний төрөл хэлбэр ангилал, менежментийн бүтэц зохион байгуулалт, удирдлага, хүний нөөц, цаашдын хөгжил зэргийг дэлгэрэнгүй тусган харуулсан. Мөн жижиг дунд бизнесийн эдийн засаг, санхүү татвар ноогдуулалт, хөрөнгө оруулалт эрсдлийн талаар тайлбарласан. Ном нь их дээд сургуулийн багш, окутан, суралцагсад болон жижиг дунд бизнес эрхлэгчдэд зориулагдсан.



Пүрэвдагва Х., Оюунчимэг Д.
Менежмент: Жишээ, дасгал, сорил.-
УБ., 2008.- 416х.- ISBN 978-99929-75-44-Х

Энэхүү ном 18 бүлгээс бүрдэж байгаа ба 1-р бүлэгт байгууллага, менежмент, менежер гэсэн ойлголтуудыг авч үзсэн бол удирдлагын сэтгэлгээний хөгжил менежментийн ухааны сэтгэлгээний хөгжлийн тойм, шинжлэх ухаан сэтгэлгээ зэргийг 2-р бүлэгт хамруулан үзсэн байна. Мөн стратеги ба төлөвлөлт, зохион байгуулалт, мотиваци, хяналт, манлайлал, хүний нөөцийн менежмент, удирдлагын менежмент ... зэргийг

дараагийн бүлгүүдэд дэлгэрэнгүй тусгасан.

Хүрэлсүх С., ба бус

Монгол улсын эдийн засгийн динамик загвар / Хүрэлсүх С., Хэнмэдэх Л., Од М.; Ред.Б.Баяржаргал.- УБ., 2008.- 56х.

Уг номонд эдийн засгийн онолын түүхээс эхлэн физик эдийн засгийн математик үндэслэл, таваарын бүлэглэл, хэрэглээний функц, үйлдвэрлэлийн функц, нийгэм эдийн засгийн функц, макро эдийн засгийн динамик загварчлал зэргийг цогцоор нь ойлгоход тус дөхөм болно.



Менежментийн шинэ парадигма:
Төлөвшил, хөгжлийн үндсэн хандлага /
Я.Шуурав, Л. Отгонтуяа, Б.Баясгалан, ба
бус; Ред.Г.Цэрэндагва.- УБ., 2007.- 256х.
ISBN 99929-81-53-09

Уг ном нь менежментийн хөгжлийг тодорхойлогч хүчин зүйлүүд, менежментийн шинэ парадигмагийн үндсэн бодомжуудын талаар ойлгоход тус дөхөм болно. Мөн бенчмаркингийн тухай, түүний үзэл баримтлалын үүсэл хөгжлийн талаар тусган харуулсан байна.



Питер Друкер

Мэргэжлийн менежмент / Хянан тохиолд. О.Чинзориг.- УБ.: Мөнхийн үсэг., 2007.- 312х.- ISBN 978-99929-1-234-0

Энэхүү номонд менежерийн үүрэг хариуцлага гэж юуг хэлдэг талаар, мөн бизнесийн онол, бизнесийн үр дүнг яаж дээшлүүлэх талаар авах арга хэмжээ... зэргийг тусгасан. Ном нь менежерүүд, бизнесийн зөвлөхүүд болон санхүү, эдийн засгийн чиглэлээр суралцаж буй оюутнуудад зориулагдсан.

Баярмаа Д.

Маркетерийн бичил судар буюу англи хэлийг маркетингийн хамт сурах боломж.-УБ.: Бемби сан, 2008.- 199х.

Номын эхний хэсэгт англи нэр томъёонуудыг монгол хэл дээрх тайлбарын хамт оруулсан болно. Хоёрдугаар хэсэгт маркетингийн зарим нарийн танилцуулагыг, харин гуравдугаар хэсэгт маркетинг болон зар сурталчилгааны талаар ухаантнуудын хэлсэн үгсийг англи ба монгол хэл дээр хамтад нь оруулсан нь мэргэжлийн нэр томъёонуудыг цээжлэхэд дөхөм үзүүлнэ.



Хэл, хэлний шинжлэл:

Нансалмаа Н.

Русская грамматика в таблицах, схемах и иллюстрациях / Ред. Ш.Туяа.- УБ.: Издательство МонГУ., 2008.- 230с. ISBN 978-99929-53-66-7



Энэхүү сурах бичигт орос хэл эхлэн үзэж байгаа оюутнуудад зориулан орос хэлний дүрмүүдийг багтаасан байна. Энэ ном нь бас өөрийн дүрмийн мэдлэгээ сайжруулах хүсэлтэй байгаа хүн бүхэнд зориулсан байна. Сурах бичгийн материал нь даалгавар биелүүлэхэд хэрэглэгдэх жишээ болон схемүүдийг оруулсан байна.

Эрчим Хүчний Инженерийн Сургууль

ЭХИС, УУИС



Мөнхдулам Д.

Төрийн санхүү: Сурах бичиг.- УБ.: Мөнхийн үсэг., 2008.- 334х.


Уг номонд Монгол улсын санхүүгийн шинэчлэлийн нөхцөл дахь улсын ба орон нутгийн санхүүгийн эдийн засаг, зохион байгуулалт, эрх зүйн асуудлуудыг авч үзсэн байна. Номонд дараах гол асуудлыг авч үзсэн байна. Үүнд:

- Санхүүгийн онолын үндсэн үүрэг
- Улсын санхүү түүний гүйцэтгэх үүрэг
- Төсвийн болон татварын үйл ажиллагааг зохицуулах улсын бодлого, арга хэлбэр
- Улсын болон орон нутгийн санхүү, төсвийн

онцлог улсын өрийн удирдлага... зэрэг асуудлууд багтсан байна.

Геологи Газрын Тосны Сургууль 5 төрлийн 50 ширхэг ном авсан

ГГТС, УУИС



Палам Б., Гарамжав Д.

Монгол газрын ховор эрдэнэс / Хянан тохиолд. Д.Сангаа; Ред. Б.Хулан.- УБ.: Тод., 2008.- 239х.- ISBN 99929-5-444-2

Уг номонд газрын ховор эрдэнэ хэмээх алт эрдэнэсээс ч өндөр үнэтэй баялаг эх орны газар шороонд хадгалагдсаар байгааг дурьдан тэднийг нээх арга зам, технологийн талаар тайлбарлан үзүүлсэн.



Төвхөө Л., Баттөгс Г.

Өрөмдлөгийн монгол-англи-орос техникийн түгээмэл үг, хэллэгийн толь / Хянан тохиолд. Ж.Цэвээнжав.- УБ., 2008.- 166х.- ISBN 978-99929-63-09-3

Тус толь бичигт өрөмдлөгийн мэргэжлийн сургалтанд өргөн хэрэглэгддэг 9000 гаруй ерөнхий техникийн үг хэллэгүүдийг оруулсан болно. Өрөмдлөгийн техник технологийн сургалтын англи, орос, монгол хэлний техникийн түгээмэл үг, хэллэгийг эзэмшихийг хүссэн бүх түвшний

суралцагчдад зориулав.

Төвхөө Л., Баттөгс Г.

Буровой общетехнический русско-монголо-английский словарь / Ред. Ж.Цэвээнжав.- УБ., 2008.- 182х. ISBN 978-99929-63-08-5

Толь бичиг нь өрөмдлөгийн талаарх техникийн зохиолд өргөн хэрэглэгддэг 9000 нэр томъёо болон нэр томъёоны харьцуулалтыг агуулсан байна. Өрөмдлөгийн чиглэлээр суралцаж байгаа оюутнуудад зориулагдсан байна.



Battugs G., Tuvkhuu L.

The English-mongolian-russian dictionary commonly used drilling expressions and terminology / Edited by J.Tseveenjav.- УБ., 2008.- 182p.

Толь бичиг нь өрөмдлөгийн талаарх техникийн зохиолд өргөн хэрэглэгддэг 9000 нэр томъёо болон нэр томъёоны харьцуулалтыг агуулсан байна. Толь бичиг нь Англи монгол ба орос хэлний техникийн өрөмдлөгийн нэр томъёонуудыг агуулсан байна.

Болдбаатар Л.

**Дээд боловсролын менежмент:
Өөрчлөлт шинэчлэлт, онол арга зүй**
/ Ред. А.Бат-Эрдэнэ, Б.Болорчимэг.- УБ.,
2008.- 183х.- ISBN 978-99929-51-67-2

Энэхүү эмхтгэлд дээд боловсролын удирдлага, санхүүжилтийн тулгамдсан асуудлуудыг улсын төсөвт оруулах төрийн бус дэмжлэг, удирдлага санхүүжилтийн шинэчлэлт, дээд боловсролын байгууллагын радикал өөрчлөлт шинэчлэлт сэдвийн дотор оруулсан байна. Түүнчлэн оюутны сургалтын зээлийн хэлбэрүүд, докторын сургалтын хэв загварын олон улсын түвшин, болон үйл явц, инженерийн хөгжлийн бодлогын асуудал зэрэг нийтлэлүүдээс гадна өөрийн оюутны эквивалентийн аргыг нөөц хуваарилалтын математик загварт хэрэглэх, оюутны зээлийн статик, динамик загварын талаарх онол, арга зүйн нийтлэлүүд энэхүү эмхтгэлд орсон байна.



Хүмүүнлэгийн Ухааны Сургууль нийт 7 төрлийн 50 ширхэг ном авсан

Амаржаргал Т., Туяа С.

Нийгмийн ажлын онолын үндэс
/ Хянан тохиолд. Т.Оюунбилэг.- УБ., 2008.-
119х.- ISBN 978-99929-51-61-3





Уг гарын авлагад нийгмийн ажлын сэтгэлгээний түүхээс эхлэн, мөн чанар, объект, судлах зүйл, хууль зүй тогтол, үндсэн зарчим загварын хэв маягууд зэрэг нийгмийн ажлын хэв шинжүүд орсон байна. Мөн нийгмийн шинжлэх ухаан нь бусад шинжлэх ухаануудтай хэрхэн холбогддог талаар дурьдсан. Жишээ нь Нийгмийн ажил ба философи, социологи, сэтгэл судлал, сурган хүмүүжүүлэх ухаан зэрэг шинжлэх ухаан юм.

Амаржаргал Т., Ариунтуяа Н.

Сэтгэл зүйн шилдэг тестүүд:
Цуврал 2.- УБ.: Сэлэнгэпресс, 2008.-
157х.- ISBN 978-99929-70-76-6

Энэхүү номонд сэтгэл судлалын шинжлэх ухаанд өргөн хэрэглэж байгаа проектив болон бие хүний зан төлөв, темперамент, сэтгэлийн хөдөлгөөнийг судалдаг тестүүдийг оруулсан Сэтгэл зүйч, нийгмийн ажилтан, эмч нар болон сэтгэл судлал, нийгмийн ажлын ангийн оюутан залууст зориулагдсан.





Шинжлэх ухааны философи:
Сурах бичиг/ Ред. А. Энхбаатар,
Д. Ганболд.- УБ.: Admon., 2008.-325х.
ISBN 978-99929-0-467-4

Шинжлэх ухааны тvvхэн өсөлтийн тухай, сциентизм, антисциентизмын хоршлын тухай асуудлыг задлан шинжлэхийн зэрэгцээ, анх удаа К.Циолковский, В.Вернадский, Л.Гумилев зэрэг оросын шинжлэх ухааны философичдын сан хөмрөгөөс сэдэвчлэн тусгажээ.

Пүрэвсүрэн Б.

Соёлын эрх чөлөө ба бодлого
/ Хянан тохиолд. А.Энхбаатар.- УБ.: Адмон,
2008.- 96х.- ISBN 978-99929-0-563-8

Зохиогч бүтээлээ 2 хэсэгт ангилан эхний хэсгийг нь дурьдсан чиглэлд хандуулж хоёрдугаар бүлгийг нь өмнөх санаан дээрээ үндэслэсэн бодол эргэцүүллийн түвшинд монгол дахь соёлын эрх чөлөөний нөхцөл байдал, түүнд чиглэсэн асуудлыг авч үзсэн байна. Энэ бүтээл нь хүн соёлын эрх чөлөөгөө эдэлж хэрэглэж эс чадваас соёлоороо хэрхэн гадуурхагдаж болохыг харуулахыг эрмэлзэхийн зэрэгцээ соёлыг урлагаас мөн иргэншлээс тус тус ялган ойлгож хэрэглэж сурахыг хүсэмжилсэн агуулга бас шингэсэн байна.




Наранцацрал Д.

Рембрандт Харменс Ван Рейн
/ Ред.Л.Батчулуун.- УБ.: ШУТИС-ийн ХҮСТ.,
2007.- 48х.- ISBN 978-99929-822-1-7

Уг номонд алдарт зураач Рембрандтын амьдрал, уран бүтээл, уран бүтээлч болсон ахуй, шилдэг туурвилууд, зураасан зургуудыг бичсэн байна. Энэхүү

номыг CD хэлбэрээр хамт гаргасан болно.





Gantsetseg J., Dugarmaa S.

**English for tourism / Edited by
N.Galima.- UB., 155p.- ISBN 978-99929-51-
75-3**

Энэ ном нь аялал жуулчлалын мэргэжлээр сурч байгаа оюутнуудад зориулагдсан байна. Энэ номонд аялал жуулчлалын менежментийн англи нэр томъёонуудыг агуулсан дасгал ажлууд, толь бичиг, хэлу үгнүүд, текстүүдийг агуулсан байна.

**Монголын нийгмийн өөрчлөлт
/ Ред.Б.Даш-Ёндон.- УБ., 2008.-512х.
ISBN 978-99929-871-7-0**

Энэхүү эмхтгэлд монголын нийгмийн амьдралд гарсан язгуур өөрчлөлтийг философи, социологи, улс төр судлал, эрх зүйн болон эдийн засгийн ухааны үүднээс шинжилж дүгнэлт гаргасан байна. Гэхдээ асуудлыг гол төлөв философи сэтгэлгээ, философичилсон судалгааны үүднээс авч үзэхийг оролдсон.



**Уул Уурхайн Инженерийн Сургууль нийт 4 төрлийн 60
ширхэг ном авсан**

Тэгшжаргал Н.



**Шинэ зууны оюутан / Хянан
тохиолд. П.Эрдэнэбат.- УБ., 2008.- 254х.-
ISBN 978-99929-1-401-7**

Улс орны зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжиж байгаа мэдээллийн эрин болох өнөө үед шинэчлэл, дэвшлийн үндэс, баталгаа нь иргэдийн болосрол. 16-22 насны залуус өөрийнхөө физиологи, оюун ухаан, сэтгэл зүйн нөөц боломжоо танин мэдэж өөрийгөө нээх, өөрийнхөө оюуны чадамжаа хэрхэн хөгжүүлэх ажил хэрэгч бүтээлч мэргэжилтэн болох арга замын тухай энэхүү гарын авлагад зөвлөсөн байна.

**Математикийн Сургууль нийт 2 төрлийн 40 ширхэг
НОМ авсан**



MT101 Математик 1: Хичээлийн семинарын гарын авлага / Ж.Баасандорж, Да.Нямсүрэн, Г.Яргай, ба бус; Ред. Да.Нямсүрэн, Г.Яргай.- УБ.: Стартлайн., 2008.- 130х.

Тус гарын авлагад семинарын хичээлүүдийг сэдэв тус бүрээр хувааж, онолын хэсгийг бодлого, дасгалын хамтаар оруулж бүх хариуг хавсаргасан байна. Мөн MT101 Математик 1 хичээлийн бие даах ажлуудын сэдвүүдийг 30 вариантаар боловсруулан хавсаргасан нь чухал ач холбогдолтой болжээ.

Лощенка А.В., Ариунаа Ү.

Комплекс анализ ба үйлдлийн тооллын бодлого бодох гарын авлага .- УБ.: Соёмбо принтинг., 2008.- 144х.

Энэхүү гарын авлага нь оюутны бие даасан үйл ажиллагааг хөгжүүлэх комплекс хувьсагчийн функцийн онол ба үйлдлийн тооллын нэн чухал зарим бодлогыг бодох дадлага олгох улмаар тэдний математик бэлтгэлийг өндөржүүлэхэд оршино.



**Компьютер Тенхик Менежментийн Сургууль (10%)
1 төрлийн 20 ширхэг ном төв номын санд өгсөн**



Цахилгаан хэлхээний онол ба бодлогууд : Сурах бичиг I, II дэвтэр / Орч. А.Батмөнх . – УБ., 2007 .

ISBN 99929-73-47-1

Энэ номны эхний хэсэгт цахилгаан хэлхээний Үндсэн ойлголт, хуулиуд зэрэг суурь ойлголтын сэдвүүдийг агуулсан бол хоёрдугаар хэсэгт үйлдлийн өсгүүр, дохионы ангиллын талаархи, Фурье ба Лапласын анализын тухай болон сэдэв бүрт харгалзах бие дааж бодох бодлогуудыг багтаасан байна.



Татвар төлөгчдөд зориулсан эрх зүйн баримт бичгийн эмхтгэл

/Эмхт.Б.Нямхүү ; Ред.У.Мөнхбат .- Улаанбаатар., 2008.- 496х.

Энэхүү эмхтгэлд татвар төлөгч иргэн, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд холбогдох Монгол улсын хууль түүнийг хэрэгжүүлэхээр гаргасан тогтоол, тушаал зэрэг эрх зүйн баримт бичиг тусгагджээ.



Намсрай Х. ба бус



